



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 107

Улаанбаатар хот

Сурагчдын лиг Сагсан бөмбөгийн тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 34 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2017 оны зорилтыг үндэслэн ТУШААХ нь:


1. Улаанбаатар хотын аварга шалгаруулах Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын лиг сагсан бөмбөгийн тэмцээнийг 2017 оны 02 дугаар сарын 13-18-ны өдрүүдэд Буянт-Ухаа спортын ордонд зохион байгуулсугай.

2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 15,376,000 /арван таван сая гурван зуун далан зургаан мянган/ төгрөгийг Нийслэлийн нийтийн биеийн тамир, спортын хорооны спортын уралдаан тэмцээний төсвийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.

4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг мэргэжилтэн /Б.Түвшинбаяр/-д үүрэг болгосугай.


ДАРГА



Ж.ГАНБОЛД

1150500016

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны
даргын 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн
А/07 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт




Сурагчдын лиг Сагсан бөмбөгийн
тэмцээн зохион байгуулах тухай

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Тамирчдын шагнал: 1-р байр 72 хүн x 10.000 ₮ = 720.000 2-р байр 72 хүн x 8.000 ₮ = 576.000 3-р байр 72 хүн x 6.000 ₮ = 432.000	1.728.000 төг
2.	Багийн шагнал: 2.700.000 төг	2.700.000 төг
3.	Шүүгчдийн ажлын мөнгө: /8 хүн x 6 өдөр x 50.000₮	2.400.000 төг
4.	Заалны түрээс	1.000.000 төг
5.	Тээврийн зардал	100.000 төг
6.	Урлаг, спортын тоглолт	1.500.000 төг
7.	Өргөмжлөл	500.000 төг
8.	Цом, ,	540.000 төг
9.	Медалийн үнэ: 156x 8.000 ₮	1.248.000 төг
10.	Анонс	300.000төг
11.	Тайз, чимэглэл,гэрэлтүүлэг	1.500.000төг
12.	Үйлчилгээ,	200.000төг
13.	Талбай татах өнгийн туузан скоц, батарей авах	160.000 төг
14	TV-ээр шууд дамжуулах, шторк сурталчилгааны зардал	1.500.000төг
Нийт дүн		15.376.000 төг

Боловсруулсан:
Хянасан:

Б.Түвшинбаяр
О.Эрдэнэцэцэг

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны
даргын 2017 оны *02 дугаар* сарын *08*-ны өдрийн
007 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Сурагчдын лиг Сагсан бөмбөгийн
тэмцээн зохион байгуулах тухай

- | | |
|-----------------------|---------------|
| 1. Ерөнхий шүүгч | С.Саранцэцэг |
| 2. Нарийн бичиг шүүгч | Л.Нацагдорж |
| 3. Нарийн бичиг шүүгч | Н.Батбаатар |
| 4. Эмч шүүгч | Ё.Энхтайван |
| 5. Шүүгч | Г.Болд |
| 6. Шүүгч | Б.Цэрэндолгор |
| 7. Шүүгч | Б.Түвшинбаяр |
| 8. Шүүгч | Ш.Мөнх-Эрдэнэ |